

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Байшин барилгын- Үл хөдлөх хөрөнгийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2021-01-18		ЗТ-21/01-020	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Байшин барилга- Үл хөдлөх хөрөнгө					
	Даатгалын үндсэн эрсдэл	-					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,07% - 1,00%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Гэрээнд заагдаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол болон даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө учирсан аливаа хохирол, түүнээс үүссэн бусад хохирол;
2. Даатгалын зүйлийн ердийн элэгдэл, үл хөдлөх эд хөрөнгийг барьсан барилгын материалын хэвийн хорогдол, ууршилт, шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;

3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийг бусдад барьцаалуулах, түрээслэх, зээлдүүлэх, болон ашиглуулах үед гарсан хохирол болон даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид 30 хоногт багтаан мэдэгдээгүй үед учирсан хохирол;
4. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
5. Үйлдвэрлэлийн дефектээс болон буруу суурилуулсан, угсарсан, задалсанаас үүдэн гарсан болон тэдгээрийг засварласан аливаа зардал;
6. Газар хөдлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөнөөс үүссэн хөрсний гулгалтын улмаас даатгалын зүйлд учирсан хохирол;
7. Даатгалын тохиолдлын бус үед зайлшгүй сэргээн засварлахтай холбогдон гарах зардал;
8. Даатгуулагч даатгалын зүйлд засвар, өргөтгөл, хийцийн өөрчлөлт хийхээсээ өмнө Даатгагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл аваагүй бол уг өөрчлөлт болон өөрчлөлт хийхээс үүдэн даатгалын зүйлд учирсан хохирол;
9. Даатгалын зүйл, түүнд суурилуулсан техник, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалтын горим, журам, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам, норм, дүрэм эсхүл барилгын норм, стандарт, норматив зөрчсөн, урсгал засвар хийх шаардлагатай болон ашиглалтын хугацаа заасан эд ангиудад зайлшгүй хийгдэх засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд хийгээгүйгээс даатгалын зүйлд учирсан хохирол;
10. Барилга байгууламжид суурилуулсан даатгуулагчийн хаяг, самбарт учирсан хохирол.
11. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулаагүй, галын аюулгүй байдлын тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирол;
12. Даатгуулагчийн өөрийн гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
13. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал, үйл ажиллагаа тасалдсан хугацааны хохирол, эдийн бус хохирол;
14. Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй байгаль орчин болон гуравдагч этгээдэд учирсан хохирол;
15. Даатгуулагч даатгагчидтай тохиролцолгүйгээр даатгалын зүйлийг нөхөн сэргээсэн нь хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд;
16. Барилгыг батлагдсан зураг төслийн дагуу бариагүй, барилга байгууламжийн норм, нормативын шаардлагыг хангаагүйгээс үүдэн гарсан хохирол;
17. Барилгын тухай хуульд заасны дагуу ашиглалтанд оруулаагүй, ашиглалтын гэрчилгээ олгож, паспортжуулаагүй барилга байгууламжид учирсан хохирол;
18. Хууль тогтоомжид заасан бусад.